



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 08 сарын 23 өдөр

Дугаар 398

Улаанбаатар хот

### Автомашины тоо, төрөл тогтоох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоолын 5 дугаар заалт, Монгол улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Сангийн сайдын хамтарсан 2022 оны 95/260 дугаар тушаалаар баталсан "Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн албан ажлын хэрэгцээнд автомашин ашиглах нийтлэг журам"-ын 3.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Шүүхийн сахилгын хорооны үйл ажиллагааны онцлог, цар хүрээг харгалзан үндсэн үйл ажиллагаа, дотоод албан хэрэгцээнд ашиглах үйлчилгээний автомашины тоо, төрлийг хавсралтаар баталсугай.

2. Шүүхийн сахилгын хорооны дарга Ц.Давхарбаярт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Холбогдох хууль тогтоомжийн дагуу байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор үйлчилгээний автомашин ашиглалтыг сайжруулах ажлыг зохион байгуулах;

2.2.Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн албан ажлын хэрэгцээнд автомашин ашиглах нийтлэг журмын хэрэгжилтийг хангах;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2024 оны 4 дүгээр улиралд багтаан тайлагнах.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА



Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2024 оны 08 дугаар сарын 23 ны өдрийн  
.....3.98..... дүгээр тогтоолын хавсралт



ШҮҮХИЙН САХИЛГЫН ХОРООНЫ ДОТООД АЛБАН АЖЛЫН ХЭВЭГЦЭЭНД АШИГЛАХ  
АВТОМАШИНЫ АНГИЛАЛ, ТОО, ТӨРӨЛ

| Д/д | Үндсэн ангилал                                    | Төрөл                                                                   | Тоо |
|-----|---------------------------------------------------|-------------------------------------------------------------------------|-----|
| 1   | Үндсэн үйл ажиллагаанд ашиглах үйлчилгээний машин | Туулах чадвар сайтай хөдөө ажлын автомашин                              | 3   |
|     |                                                   | Хот доторх ажлын суудлын автомашин (Нийслэл орчимд хяналт шалгалт хийх) | 6   |
|     |                                                   | Бага оврын автобус, старикс                                             | 1   |
|     |                                                   | Нийт автомашин                                                          | 10  |